



2020-21 онд хэрэгжүүлэх төслүүд

Хайгуулын тусгай зөвшөөрлийн зохицуулалтыг шинэчлэхэд техникийн туслалцаа үзүүлэх. Энэ төслийн хүрээнд УУХҮЯ-тай хайгуулын

тусгай зөвшөөрлийн зохицуулалтыг шинэчлэхэд хамтран ажиллана. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох хууль эрх зүйн орчин нь Монгол улсын өрсөлдөх чадварын нэг үзүүлэлт байдаг. Энэ төслийн хүрээнд Монгол улстай ижил төстэй Австралийн зарим муж улсын хайгуулын тусгай зөвшөөрлийн талаарх судалгааны тайлан, геологийн мэдээллийг тусгай зөвшөөрлийн зохицуулалтад хэрхэн ашиглах боломжтой тухай, хайгуулын тусгай зөвшөөрлийн талаарх олон улсын сайн туршлагыг судлан танилцуулна. Энэ төсөл нь Монгол улс хайгуулын тусгай зөвшөөрөл олголтод дорвитой өөрчлөлт хийх замаар өрсөлдөх чадвараа дээшлүүлэн, нээлттэй бизнесийн орчин бүрдүүлэх чин хүсэлтэй байгааг хөрөнгө оруулагчдад харуулж байна.

Шинэ оны босгон дээр

Ковид цар тахал дэлхийн улс орнуудын хувьд томоохон сорилт бэрхшээл байхын зэрэгцээ аялал, хамтын ажиллагааны шинэ нормог тогтоож байна. Энэ хүнд хэцүү цагт өмнөө тавьсан зорилгоо биелүүлж, 2019-2020 оны төслүүдээ амжилттай хэрэгжүүлж дуусгасан хамтрагч нараараа АМЕР хөтөлбөрийн хамт олон бахархаж, мөн талархаж буйгаа илэрхийлье.

Шинэ оны босгон дээр бид мөн та бүхэнтэй 2020-21 онд хэрэгжүүлэх төслүүдээ танилцуулж байгаадаа баяртай байна. Манай Мэдээллийн товхимлын зургаа дахь дугаараас та бүхэн Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам, Монгол улсын Сангийн яамны баталсан зургаан төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг үзэх боломжтой. Шинэ оноо сайхан угтаарай!



**STAY HOME
STAY SAFE**

Эрэл хайгуул, нөөц баялгийг тайлагнах журам боловсруулах.

УУХҮЯ, АМЕР хөтөлбөрийн захиалгаар ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуулийн харъяа Эрдэс баялаг, геомэдээллийн сургалтын төв хөнгөн цагаан, литий-цезий, газрын ховор элемент, бал чулуу, давс, карбонат чулуулаг, элс хайрга гэсэн долоон төрлийн ашигт малтмалыг эрж хайх, нөөцийг нь тайлагнах аргачилсан зааварчилгаа боловсруулна. Энэ зааварчилгааг мөрдөж, стандартчилснаар дээрх долоон ашигт малтмалын нөөц тогтоох, бүртгэх үйл явцыг ойлгомжтой, үр дүнтэй, ил тод болгоно.

Байгаль орчны аудитын институтын чадавхийг нэмэгдүүлэх.

2019 оны 12 дугаар сард батлагдсан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/809 дүгээр тушаалаар Монгол улсад байгаль орчны аудит хийж гүйцэтгэх ерөнхий зааврыг баталсан. Харин энэ зааврыг хэрэгжүүлэх арга аргачлал боловсруулж, сургалт явуулснаар Монголын байгаль орчны аудиторууд ерөнхий зааврыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх боломжтой болох юм. Тиймээс БОАЖЯ, АМЕР хөтөлбөр хамтран, Байгаль орчны аудитын холбоо (БОАХ) байгаль орчны аудиторуудын мэргэшсэн байдлыг гэрчилгээжүүлэх, аудиторуудын мэдлэг, ур чадварын стандарт, ёс зүйн хэм хэмжээг тусгасан сургалтын модулиудыг боловсруулахад нь дэмжлэг үзүүлэхээр боллоо. БОАХ мөн хараат бус байдлаар, бие даан ажиллах, байгаль орчны аудиторуудад мэргэшсэн байдлыг баталгаажуулж гэрчилгээ олгох, компаниудын чанарын гүйцэтгэлийг батламжлахад шаардагдах бүтэц, удирдлага, зохион байгуулалт хийх шаардлагатай байгаагаа илэрхийлсэн. Энэ төсөл нь Монгол улсад байгаль орчны аудитын үйл ажиллагааны чанар, стандартыг сайжруулах, хуулинд заасан шаардлагуудыг аудитын компани, аудиторууд биелүүлдэг болоход чухал ач холбогдолтой. Аудитын чанар, стандартыг тодорхой болгож, сайжруулснаар уул уурхайн компаниудын байгаль орчны менежментэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, салбарын хэмжээнд байгаль орчны ерөнхий гүйцэтгэлийг ахиулах боломжтой.

Дагалдах элементүүдэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ) тооцох.

Сангийн яам (СЯ), Татварын ерөнхий газар (ТЕГ), Ашигт малтмал, газрын тосны газар, Гаалийн ерөнхий газартай зөвлөлдсөний үндсэн дээр УУХҮЯ ашигт малтмалын баяжмалд агуулагдах дагалдах элементүүдэд ногдуулах АМНАТ-тэй холбоотой журам, заавруудыг шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна. Энэ хүрээнд АМЕР хөтөлбөр гурван ажил хийж гүйцэтгэнэ.



2020-21 онд хэрэгжүүлэх төслүүд (үргэлж.)

Нэгдүгээрт, баяжмалд агуулагдах дагалдах элементэд нөөцийн төлбөр ногдуулах олон улсын шилдэг туршлага, эрх зүйн зохицуулалтыг судална. Хоёрт, дагалдах элементүүдийг тооцоолох шинэчилсэн арга зүй боловсруулна. Гуравдугаарт, Монгол, Австралийн Сангийн яамны мэргэжилтнүүдийг холбож, АМНАТ тооцох аргачлал, Австралийн туршлага судлах цахим уулзалтууд зохион байгуулна. Энэ төсөл нь Монгол улсын ашигт малтмалын АМНАТ тооцох хуулиудад буй зөрүүтэй заалтуудыг засч сайжруулах, УУХҮЯ, СЯ, ТЕГ-ын мэргэжилтнүүд нэгдсэн ойлголттой болоход нь чухал ач холбогдолтой. Монгол улс өрсөлдөх чадвараа дээшлүүлэхийн тулд салбарын хэмжээний шинэчлэлтүүд хийхэд бэлэн буйг энэ төсөл олон улсын хөрөнгө оруулагчдад харуулна.

Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийхэд иргэдийн оролцоог сайжруулах нь.

Монгол улсад байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийхэд мөрдөгддөг дүрэм журамд өөрчлөлт оруулах шаардлага байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор АМЭП хөтөлбөр БОАЖЯ-тай зөвлөлдөн, нэг сум сонгож, судалгаа хийнэ. Энэ кэйс судалгаа нь хэд хэдэн асуултад хариулт олох зорилготой. Тухайлбал, нутгийн иргэдэд хурлын зар амжилттай хүргэх, хурлыг үр дүнтэй зохион байгуулах, хэдэн хүн оролцсон байх ёстой, төлөөллийг хэрхэн хангах, иргэдийн санаа бодлыг яаж тэмдэглэн авах, тэдгээрийг

тайлан илтгэлд хэрхэн тусгах, БОАЖЯ-нд хүргүүлэх, хурлын сэдэв байгаль орчны нөлөөлөх байдлын дэлгэрэнгүй үнэлгээтэй холбоотой асуудлуудад төвлөрсөн эсэх зэрэг асуулт болно. Кэйс судалгааны үр дүнд тулгуурлан, АМЭП хөтөлбөр Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 онд баталсан А-03 тушаалд өөрчлөлт оруулах санал боловсруулахаар төлөвлөж байна. Уурхайн төсөл эхлэхээс өмнө буюу төслийн эхний үе шатанд орон нутгийн иргэд, засгийн газар, уурхайн компани хоорондоо үр дүнтэй, эерэг харилцаа үүсгэж, байгаль орчны нөлөө, менежментийн асуудлаар шийдвэр гаргадаг болоход сайдын тушаалд оруулах нэмэлт өөрчлөлт ач холбогдолтой юм.

Зохистой татварын хэмжээ, судалгаа.

Эрдэс баялгийн салбарын өсөлтийг дэмжих зорилгоор олон улсад татварын үр нөлөөтэй хувь хэмжээг тооцоолон гаргадаг. Ингэхдээ мөрдөгдөж буй татварын хэмжээ, АМНАТ, элэгдэл хорогдлын хэмжээ, тухайн орны эрсдэл, эзэмшлийн зохицуулалт, дотоодын зардал зэрэгт үндэслэн, загварчлал боловсруулдаг. Энэ судалгааны төсөл нь Монгол улс өрсөлдөх чадвараа дээшлүүлэхэд анхаарч буйг олон улсын хөрөнгө оруулагчдад харуулна. Монгол улсын Засгийн газар Ковид-19 цар тахлаас үүдэн гарах эдийн засгийн хүндрэлийг даван туулах, салбарын өсөлтөд анхааран ажиллаж буй энэ үед тус судалгаа хувь нэмрээ оруулна гэж үзэж байна.

МАНАЙ ЗОРИЛТ:

// Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар МУ-ын эрдэс баялгийн салбар дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад хувь нэмэр оруулах. //



The global pandemic has indeed tested our perseverance and set a new normal in terms of travel and collaboration. We are beyond thankful for the support and effort our partners have put in to achieve the objectives set out in 2019-20 activities. It is also a great pleasure to share with you what AMEP will be implementing in 2021.

In this newsletter, you will find out about six activities the Department of Foreign Affairs and Trade of Australia and the Ministry of Finance of Mongolia approved for AMEP to implement in 2021. These activities were selected to meet the overarching goal to contribute to the enabling investment environment in the Mongolia's extractives sector. Enjoy the sixth edition of AMEP newsletter and we wish you a Merry Christmas and happy new 2021.



**STAY HOME
STAY SAFE**

Summary of Activities 2020-21

Exploration Licences Reform. AMEP is pleased to partner with the Ministry of Mining and Heavy Industry (MMHI) to examine and improve this important aspect of Mongolia's competitiveness. In particular, AMEP will help the MMHI by introducing international licencing good practices, producing a report on licencing systems in the most relevant Australian jurisdictions and considering the relationship between geo-science data and methods for allocating licences. This work signals to the investment community that Mongolia is serious about reforms to make it more competitive and open for business.

Exploration and Reporting Guidelines. In partnership with the MMHI, AMEP will engage the Center for Mineral Resources, Geo-information and Training of the Mongolian University of Science and Technology to develop methodological guidelines for geologists to standardize exploration techniques and reporting of seven key minerals, namely aluminum ore, lithium-caesium, graphite, rare earth elements, industrial salts, carbonate rocks, and sand and gravel. The widespread use of such standardised reporting of mineral reserves and resources based on these guidelines will contribute to greater efficiency, transparency, and clarity of the reserve and resource registration process.

Environmental Auditors' Certification. With the support of Ministry of Environment and Tourism (MoET), AMEP will work with the Environmental Auditors' Association of Mongolia (EAAM) to establish a certification system to assure the professional standards of auditors and a verification system for auditing companies. This will include institutional capacity building for EAAM to administer the certification and verification systems. AMEP will also develop a pilot competency-based training module for environmental auditors with a focus on applying the new methodology under Resolution A/809 as well as other professional standards and ethics. This will help EAAM to build the professionalization of the sector and the standards of environmental auditing practice, leading to higher quality audits to comply with legal requirements. Improved audits help to build public confidence in the industry's environmental management and can lift overall standards of institutional framework.

Royalties on Minor Elements. In close consultation with the MMHI, Ministry of Finance (MoF), General Department of Taxation (GDT), MRPAM, and Mongolian Customs Office, AMEP will contribute expert advice to a review of the current legal framework that results in royalties being imposed on minor elements in mineral concentrates.



**Have
Questions?**

Please visit our website www.amep.mn for more information about activities or contact Ms. Oyunbileg Purev, Partnership Manager at oyunbileg@amep.mn.

AMEP Activities: 2020-21 (Cont.)

AMEP plans to 1) conduct an assessment of international good practice with regards to the treatment of minor elements found in concentrates within royalty regimes; 2) design a revised methodology for the calculation of minor elements; and 3) connect Mongolian officials with counterparts in Australian state government treasury departments for calls or online meetings to discuss the methodology for calculating royalties in practice in Australian jurisdictions. This activity helps clarify conflicts in existing laws and regulations, achieve consensus between MMHI, MoF and GDT and signals to international investment community that Mongolia is prepared to act on reforms to improve its competitiveness.

Improved Public Participation in Environmental Impact Assessments. Under this activity, AMEP will select a pilot soum in consultation with MoET and examine public participation in Detailed Environmental Impact Assessment (DEIA) to determine whether amendments are needed to regulation to improve the process. First, a case study will be done to seek answers to questions, such as how optimally are meetings convened and run; how many people

attend and how representative are they; how are views recorded and incorporated into the report/ reported back to MoET; is there a proper explanation of the project and process; and are meetings focused on issues relevant to the DEIA? With this work, AMEP plans to develop recommendations for amending the Ministerial decree #A-03 2014 to improve public participation that is believed to establish positive and productive relationships between community, government, and companies at an early stage of project development, and result in better decision making around environmental impacts and their management.

Effective Tax Rate (ETR) Study is designed to model an optimal tax rate for growing the industry by taking current tax rates, royalties, depreciation allowances, country risk, ownership rules, and local costs into account. Such an undertaking signals to international investors Mongolia's seriousness to increase its competitiveness. The study will contribute to a broader agenda led by the Government of Mongolia to foster growth and assist in economic recovery after the challenges of COVID 19.

OUR OBJECTIVE:

// Help improve the investment environment for the extractives sector in Mongolia through the collaboration between the government, industry and civil society. //